



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 02 дугаар сарын 08

№ 04/11

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА ТАНАА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан байж болзошгүй гэх мэдээллийн мөрөөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 25 дугаар зүйлийн 25.1.4, 29 дүгээр зүйлийн 29.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн холбогдох баримт, албан тушаалтнаас гаргасан тайлбар, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Танай газраас "...Сүүлийн үед Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын визийн материал бүрдүүлэх зорилгоор тодорхойлолт авч, байгууллагын тодорхойлолтыг ашиглаж виз авсны дараа ажил хаяж явах, чөлөөлөгдөх хүсэлт ирүүлэх тохиолдол гарсаар байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. Цаашид албан тодорхойлолт хүссэн өргөдлийг уламжлан ирүүлэхгүй байхыг мэдэгдье" гэх агуулга бүхий гомдлыг 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 05/2387 дугаар албан бичгээр харьяа алба, хорих анги, нэгжийн удирдлагад хүргүүлжээ.

2. Энэ талаараа танай газраас "... Тус байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.15 дахь хэсэгт алба хаагч гадаад улсад хувийн зорилгоор аялах тохиолдолд ажил байдлын тодорхойлолт хүссэн хүсэлтийг салбар нэгжийн даргаар уламжлуулан Захиргаа удирдлагын газарт хүргүүлнэ. Ажил байдлын тодорхойлолтыг тус байгууллагад 10-аас дээш жил ажилласан алба хаагчид олгоно. 8 дугаар зүйлийн 8.16 дахь хэсэгт гадаад улсад эмчилгээ, оношилгоо хийлгэх, гэр бүлийн гишүүнийг асрахаар явах тохиолдолд энэ журмын 8.15-т заасан ажилласан хугацаа хамаарахгүй. Тус журмын дагуу ажилласан жилийн шаардлага хангасан болон хүндэтгэн үзэх шалтгаан, ар гэрийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, гадаад улсын элчин сайдын яамдад тодорхойлолт гаргаж өгч шийдвэрлэж байна. Тус байгууллагад шинээр ажилд орсон алба хаагчид визийн материал бүрдүүлэх зорилгоор тодорхойлолт авч, виз авсны дараа "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт зааснаар хувцасны тооцоо хийхгүй, ажил хаяж явах, ажлаас чөлөөлөгдөх өргөдөл өгөх тохиолдол нэлээдгүй гарч байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тул эрсдэлээс урьдчилан сэргийлж, дээрх чиглэлийг харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн дарга нарт хүргүүлсэн" гэх тайлбарыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 05/225 дугаар албан бичгээр Комисст ирүүлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно”, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй, 13.2 дахь хэсэгт “Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очиж эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй”, 12.2 дахь хэсэгт “Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй”, 12.3 дахь хэсэгт “Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй” гэж чөлөөтэй зорчих эрхийг баталгаажуулсан байна.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зорчих, цагаачлах эрхийг Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцүүлэн баталгаажуулж, 5 дугаар зүйлд гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх 5 үндэслэл (1/ Гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл; 2/ Эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл; 3/ Хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан бол уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор; 4/ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурорын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэрт заасан хугацаагаар; 5/ Хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортоо гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар)-ийг тодорхойлжээ.

Гадаад улсын иргэнд хил нэвтрэх зөвшөөрөл (виз) олгох эсэх нь аливаа улсын дотоод хэрэг, бүрэн эрхийн асуудал юм. Албан байгууллагын тодорхойлолт нь хувь хүнд хил нэвтрэх зөвшөөрөл олгоход харгалзан үзэх баримт бичиг бөгөөд виз хүсэгчийн санхүүгийн байдал, хөрөнгө нь тухайн улсад зорчих, оршин суух зардал, визийн хугацаа дууссаны дараа тухайн улсыг орхин явах, эх орондоо эргэж ирэх хангалттай баталгаа болж чадахгүй тохиолдолд виз олгоход харгалзах үндсэн баримт бичиг болж болно. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, төрийн албан хаагчийн цалин хөлсний өнөөгийн байдалд албан байгууллагын тодорхойлолт нь Монгол Улсын иргэнийг гадаад улсад чөлөөтэй зорчих эрхээ хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлох боломжтой. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.15 дахь хэсэгт “Алба хаагч гадаад улсад хувийн зорилгоор аялах тохиолдолд ажил байдлын тодорхойлолт хүссэн хүсэлтийг салбар нэгжийн даргаар уламжлуулан Захиргаа удирдлагын газарт хүргүүлнэ. Ажил байдлын тодорхойлолтыг тус байгууллагад 10-аас дээш жил ажилласан алба хаагчид олгоно” гэж заасан, алба хаагчид Бүгд Найрамдах Солонгос Улсын визийн материал бүрдүүлэх зорилгоор тодорхойлолт хүсэж байгаа нь “байгууллагын хэвийн үйл

ажиллагаанд сөрөг нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсэж болзошгүй” тул албан тодорхойлолт хүссэн өргөдөл хүлээн авахгүй тухай 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 05/2387 дугаар албан бичгээр өгсөн чиглэл нь Монгол Улсын иргэний чөлөөтэй зорчих эрхийг дангаараа, шууд зөрчихгүй боловч хязгаарлах үр дагавартай байна.

Албан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс ажилтанд олгох зарим хөнгөлөлт, дэмжлэг, боломжийг шинээр ажилд орсон ажилтан эдлэх эрх нээгдэх хүртэл ажилласан хугацааны зэрэг хууль ёсны, зохистой шаардлага тавьж болно. Жишээлбэл, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ээлжийн амралт эдлэх эрх хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш зургаан сарын дараа үүсдэг. Шинээр орсон ажилтан байгууллагаас ажил байдлын тодорхойлолт авах эрх нээгдэх хүртэл тодорхой хугацаа тогтоож болох боловч “10 жил ажилласан байх” шаардлага, эсвэл “тодорхой хугацаагаар огт олгохгүй байх” чиглэл нь Монгол Улсын иргэний чөлөөтэй зорчих эрхийг хэтрүүлэн хязгаарлах үр дагавартай, хүний эрх зөрчигдөж болзошгүй нөхцөлийг үүсгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад сүүлийн 1-3 жилд шинээр ажилд ороод тухайн жилдээ ажил байдлын тодорхойлолт байгууллагаас авч, гадаад улсад оршин суухаар явсан ажилтнуудын тоо, энэ байдлын улмаас байгууллагад учирсан хохирол, бэрхшээлийн талаарх баримт, мэдээллийг танай байгууллагаас Комисст ирүүлээгүй болохыг дурдах нь зүйтэй. Мөн харьяа алба, хорих анги, нэгжийн дарга нарт 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 05/2387 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлд ажилтнууд ажлаас чөлөөлөгдсөний улмаас байгууллагад үүссэн нөхцөл байдлыг “байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсэж болзошгүй” гэсэн нь уг арга хэмжээ бодит баримтад биш, таамаглалд үндэслэсэн байж болзошгүй гэж үзлээ.

Монгол Улсын иргэний чөлөөтэй зорчих эрх зөрчигдөж болзошгүй нөхцөлийг арилгуулах үүднээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах арга хэмжээ авахыг зөвлөж байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/96 дугаар тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.15 дахь хэсэгт “Ажил байдлын тодорхойлолтыг тус байгууллагад 10-аас дээш жил ажилласан алба хаагчид олгоно” гэж заасныг хөдөлмөрийн эрх зүй, хүний эрхийн зарчимд нийцүүлэн зохистой тогтоох; энэ хүрээнд ажилтан байгууллагаас ажил байдлын тодорхойлолт хүсэх эрх нээгдэх хугацаа нь нэг жилээс илүүгүй байх нь зохимжтой болохыг зөвлөж байна.

2. 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 05/2387 дугаар албан бичгээр харьяа алба, хорих анги, нэгжийн дарга нарт өгсөн чиглэлийг хүчингүй болгож, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын дээрх зөвлөмжийн дагуу өөрчлөгдсөн шаардлагыг хангасан алба хаагчид ажил байдлын тодорхойлолт олгож байх;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг, баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 45 хоногийн дотор ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Г.НАРАНТУЯА